МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

# ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 3 дугаар улирал

Улаанбаатар
2019



## 1. Төлбөрийн тэнцэл

Урсгал ба хөрөнгийн данс 2019 оны 3 дугаар улиралд 230 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 283 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 192 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -245 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 315 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 132 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 3,985 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 7.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

*Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)*




### Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9%-иар өсч 3,481 сая ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 269 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, чулуун нүүрсний экспорт 177 сая ам.доллараар (25%), мөнгөжөөгүй алтны экспорт 148 сая ам.доллараар, түүнчлэн СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 70 сая ам.доллараар (10%), нефтийн бүтээгдэхүүний импорт 8 сая ам.доллараар (3%) тус тус өссөн. Улмаар барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 149 сая ам.доллараар өсчээ.

*Дүрслэл 2. Барааны худалдаа (сая ам.доллар)*




### Үйлчилгээний худалдаа

2019 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 47%-иар буюу 169 сая ам.доллараар буурч, 192 сая ам.долларт хүрсэн. Үүнд бусад үйлчилгээний алдагдал 124 сая ам.доллар, аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал 33 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

*Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа (сая ам.доллар)*



Аялал жуулчлалын үйлчилгээний дансны орлого нь манай улсын хувьд улирлын шинж чанартай бөгөөд 3 дугаар улиралд орлого хамгийн өндөр байдаг. Жишээ нь, 2019 оны 3 дугаар улиралд цэвэр дүнгээр 149 сая ам.долларын орлоготой буюу өмнөх оны мөн үеэс 33%-иар өсчээ.

Үүнд, орох урсгал өмнөх оны мөн үеэс 19%-иар өсч, 253 сая ам.доллар байсан нь голлон нөлөөлсөн. Гарах урсгал өмнөх оны мөн үеэс 3%-иар өсч, 104 сая ам.долларт хүрч байна.

*Дүрслэл 4. Бусад аялал жуулчлал (сая ам.доллар)*




## Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 411 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар буюу 116 сая ам.доллараар өссөн үзүүлэлтэй байна. Үүнд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал голчлон нөлөөлсөн. Тайлант улиралд манай улс гадаад бонд, үнэт цаасны хүүгийн төлбөрт 104 сая ам.доллар, ногдол ашигт 49 сая ам.доллар, шууд хөрөнгө оруулагчийн зээлийн хүүгийн төлбөрт 120 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 158 сая ам.доллар, харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 1 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Дүрслэл 4. Анхдагч орлого (сая ам.доллар)




## Хоёрдогч орлого

Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2019 оны 3 дугаар улиралд Монгол улс нийт 78 сая ам.долларыг буюу өнгөрсөн оны мөн үеэс 27 сая ам.доллараар бага орлого хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 1%-иар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 22%-иар тус тус өссөн.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 20 сая ам.доллараар буурсан байна.

*Хүснэгт1. Хувийн гуйвуулга 2019,III улирал (мян ам.доллар)*

| | | Хүлээн авсан | | | | Шилжүүлсэн | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүн | жин | | Өсөлт | дүн | жин | | Өсөлт |
| **Солонгос** | KR | 29,654 | 43% | ▼ | -13% | 5,667 | 14% | ▲ | 27% |
| **Америк** | US | 4,763 | 7% | ▼ | -56% | 6,232 | 15% | ▲ | 83% |
| **Хятад** | CN | 601 | 1% | ▼ | -34% | 1,503 | 4% | ▼ | -24% |
| **Гонг Конг** | HK | 1,297 | 2% | ▲ | 57% | 261 | 1% | ▲ | 51% |
| **Англи** | GB | 969 | 1% | ▲ | 8% | 1,467 | 4% | ▲ | 39% |
| **ОХУ** | RU | 11,494 | 17% | ▲ | 3429% | 1,878 | 5% | ▲ | 7% |
| **Сингапур** | SG | 1,190 | 2% | ▲ | 20% | 1,218 | 3% | ▲ | 150% |
| **Швейцарь** | CH | 1,251 | 2% | ▼ | -7% | 236 | 1% | ▲ | 101% |
| **Герман** | DE | 2,489 | 4% | ▼ | -6% | 923 | 2% | ▲ | 1% |
| **Япон** | JP | 774 | 1% | ▲ | 22% | 1,432 | 4% | ▲ | 111% |
| **Бусад** | | 13,861 | 20% | ▲ | 187% | 19,467 | 48% | ▲ | 88% |
| **НИЙТ** | | **68,344** | **100%** | | | **40,283** | **100%** | | |

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2019 оны 3 дугаар улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 607 сая ам.доллар, харин хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах

урсгал 169 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 438 сая ам.долларын орох урсгалтай байв.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 26 сая ам.доллараар буурсан дүнтэй байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь харвал:

- Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 34 сая ам.доллараар өсч, 42 сая ам.доллар,
- Люксенбург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 32 сая ам.доллараар өсч, 38 сая ам.доллар, харин
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 59 сая ам.доллараар буурч, 18 сая ам.доллар,
- Япон улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 30 сая ам.доллараар буурч, 27 сая ам.долларын орох урсгалтай байсан байна.

*Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)*

| № | Үзүүлэлт | 2019 | | 2019.III/18.III | |
|---|---|---|---|---|---|
| | | Дүн | Хувь | Өөрчлөлт | |
| 1 | Австрали | 4 | 1% | -1 | ▼ |
| 2 | Америк | 3 | 0% | 0 | ▲ |
| 3 | Англи | 23 | 4% | 15 | ▲ |
| 4 | БНХАУ | 18 | 3% | -59 | ▼ |
| 5 | Герман | 1 | 0% | 0 | ▲ |
| 6 | Нидерланд | 0 | 0% | -1 | ▼ |
| 7 | Хонг-Конг | 39 | 6% | 27 | ▲ |
| 8 | Канад | 381 | 63% | -29 | ▼ |
| 9 | Люксенбург | 38 | 6% | 32 | ▲ |
| 10 | ОХУ | 14 | 2% | 11 | ▲ |
| 11 | Сингапур | 42 | 7% | 34 | ▲ |
| 12 | Солонгос (өмнөд) | 5 | 1% | 0 | ▲ |
| 13 | Турк | 0 | 0% | 0 | ▲ |
| 14 | Франц | 3 | 0% | -2 | ▼ |
| 15 | Япон | 27 | 5% | -30 | ▼ |
| 16 | Бусад | 7 | 1% | -24 | ▼ |
| | **Нийт** | **607** | **100%** | **-26** | ▼ |

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

- Бөөний болон жижиглэн худалдааны салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 24 сая ам.доллараар,
- Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 17 сая ам.доллараар,
- Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 11 сая ам.доллараар тус тус өссөн бол,
- Уул уурхайн салбар 50 сая ам.доллараар,
- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 19 сая ам.доллараар,
- Үл хөдлөх хөрөнгийн салбар 6 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)*

| № | Эдийн засгийн салбар | III улирал | | 2019.III/18.III | |
|---|---|---|---|---|---|
| | | 2018 | 2019 | Өөрчлөлт | |
| 1 | Барилга | 5 | 9 | 3 | ▲ |
| 2 | Боловсрол | 0 | 1 | 0 | ▲ |
| 3 | Боловсруулах үйлдвэрлэл | 2 | 1 | -1 | ▼ |
| 4 | Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 17 | 40 | 24 | ▲ |
| 5 | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 0 | 6 | 6 | ▲ |
| 6 | Мэдээлэл, холбоо | 2 | 2 | 0 | ▼ |
| 7 | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 8 | 4 | -5 | ▼ |
| 8 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 50 | 32 | -19 | ▼ |
| 9 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 0 | 11 | 11 | ▲ |
| 10 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл | 6 | 23 | 17 | ▲ |
| 11 | Уул уурхай, олборлолт | 515 | 465 | -50 | ▼ |
| 12 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 13 | 8 | -5 | ▼ |
| 13 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 10 | 4 | -6 | ▼ |
| 14 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан | 2 | 1 | 0 | ▼ |
| 15 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 0 | 0 | 0 | ▲ |
| 16 | Бусад | 2 | 1 | -2 | ▼ |
| | **Нийт** | **634** | **607** | **-26** | ▲ |

## Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2019 оны 3 дугаар улиралд 42 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 сая ам.доллараар өссөн.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Хуралдай бондын хүүгийн төлбөрт 26 сая ам.доллар,
- МИК 300 сая ам.долларын бондын хүүгийн төлбөрт 15 сая ам.долларыг эдийн засгийн харьяат бус тус тус төлсөн байна.

*Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)*




## Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд өмнөх санхүүгийн дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд, үүнд, арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүд, худалдааны зээллэг зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

2019 оны 3 дугаар улиралд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 180 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал, 143 сая ам.доллараар муудсан үзүүлэлт юм. Энэ өөрчлөлтөд арилжааны банкуудын харилцах хадгаламжийн данс буурсан нь голлон нөлөөлсөн байна.

*Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт*




## 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2019 оны 3 дугаар улиралд цэвэр дүнгээр 34,814 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,933 сая ам.доллар байна. Үүний 57%-ийг гадаад валютын албан нөөц, 30%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 8%-ийг шууд хөрөнгө оруулалт, 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 41,747 сая ам.долларт хүрчээ. Үүний 52%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 35%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 1,522 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг ерөнхий бүтцээр авч үзвэл: гадаад актив 28%-иар буюу 1,536 сая ам.доллараар, гадаад пассив 8%-иар буюу 3,058 сая ам.доллараар тус тус өссөн.

Харин данс тус бүрээр авч үзвэл: гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 1,932 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын позиц 905 сая ам.доллараар, албан нөөц 1,084 сая ам.доллараар тус тус өсч, бусад хөрөнгө

оруулалтын позиц 226 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.

Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар –475 сая, ханшийн өөрчлөлтөөр 198 сая, бусад өөрчлөлтөөр 5 сая, үнийн өөрчлөлтөөр -100 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

*Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)*

| Үзүүлэлт | 9/30/2018 | 9/30/2019 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | *дүн* | *хувь* |
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц** | **-33,292** | **-34,814** | **1,522** | **5%** |
| **I. Гадаад актив** | **5,397** | **6,933** | **1,536** | 28% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 525 | 582 | 56 | 11% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 286 | 289 | 04 | 1% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 00 | 04 | 04 | 1272% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 1,692 | 2,079 | 387 | 23% |
| 5. Нөөц актив | 2,894 | 3,978 | 1,084 | 37% |
| **II. Гадаад пассив** | **38,689** | **41,747** | **3,058** | **8%** |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 19,579 | 21,568 | 1,989 | 10% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 4,505 | 5,414 | 908 | 20% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 01 | 00 | -01 | -92% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 14,604 | 14,765 | 162 | 1% |

*Дүрслэл 6. Гадаад актив, пассив (сая ам.доллар)*




## Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэглийн 54%-ийг буюу 11,734 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 9,834 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Манай улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 7,141 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 33%,
- БНХАУ-аас 4,846 сая ам.доллар буюу 22%,
- Сингапур улсаас 1,614 сая ам.доллар буюу 7%,
- Люксембург улсаас 1,374 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 6%-ийг тус тус бүрдүүлж байна.

*Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2019 он*




## Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2019 оны 3 дугаар улиралд 289 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 5,414 сая ам.долларт хүрч, 20%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Актив:** манай эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт

цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл: Хонг-Конг 35%, АНУ 18%, Сингапур 12%, Австрали 8%, Их Британ 7%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** Монголын эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал: АНУ 23%, Их Британ 9%, Люксенбург 6%, Сингапур 3%, Хонг Конг 3%, үлдсэн 57% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж (тиймээс хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй) байна.

*Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2019 он*




## 3. Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 29,934 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2,032 сая ам.доллараар өссөн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 325 сая ам.доллараар өсч 7,374 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 48 сая ам.доллараар буурч, 1,948 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,755 сая ам.доллараар өсч, 20,612 сая ам.долларт хүрээд байна.

*Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар).*

| Үзүүлэлт | 9/30/2018 | 9/30/2019 | өөрчлөлт | | * % |
|---|---|---|---|---|---|
| | | | дүн | хувь | |
| **Нийт гадаад өр** | **27,902** | **29,934** | **2,032** | **7%** | **100%** |
| **I. Засгийн газар** | **7,049** | **7,374** | **325** | **5%** | **25%** |
| Бонд, өрийн бичиг | 3,067 | 3,095 | 28 | 1% | |
| Зээл | 3,981 | 4,279 | 298 | 7% | |
| **II. Төв банк** | **1,996** | **1,948** | **-48** | **-2%** | **7%** |
| **III. Банк** | **2,309** | **2,208.9** | **-100** | **-4%** | **7%** |
| Богино хугацаат | 777 | 680 | -97 | -13% | 2% |
| Урт хугацаат | 1,532 | 1,529 | -3 | 0% | 5% |
| **IV. Бусад сектор** | **7,676** | **8,569** | **892** | **12%** | **29%** |
| Богино хугацаат | 536 | 622 | 87 | 16% | 2% |
| Урт хугацаат | 7,141 | 7,947 | 806 | 11% | 27% |
| **V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл** | **8,871** | **9,834** | **963** | **11%** | **33%** |

*: Нийт өсөлтөд оруулсан хувь

### Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2019 оны 3 дугаар улирлын эцэст 2,209 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 100 сая ам.доллараар буурчээ.

Гадаад өрийн 41%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 16%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 902 сая ам.доллар, 348 сая ам.долларт хүрэв.

*Дүрслэл 9. Банкны салбарын гадаад өр (сая ам.доллар)*




## Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2019 оны 3 дугаар улирлын эцэст 18,403 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,855 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 53% буюу 9,834 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа, төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 375 сая ам.доллар болсон байна.

*Дүрслэл 10. Бусад салбарын гадаад өр (сая ам.доллар)*




*Мэдээллийн эх сурвалж:*

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

**ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | III улирал | | | Өөрчлөлт | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2019 | Дүн | 2018/17 | Дүн | 2019/18 |
| **I. УРСГАЛ ДАНС** | **-297** | **-567** | **-256** | **-270** | **-91%** | **310** | **55%** |
| **Бараа ба үйлчилгээний худалдаа** | **34** | **-377** | **77** | **-412** | **-1204%** | **454** | **120%** |
| **Кредит** | **1,776** | **1,995** | **2,400** | **219** | **12%** | **405** | **20%** |
| **Дебет** | **1,742** | **2,372** | **2,323** | **631** | **36%** | **-49** | **-2%** |
| **1. Бараа** | **216** | **-16** | **269** | **-232** | **-107%** | **285** | **1803%** |
| 1.1 Экспорт Ф.О.Б (кредит) | 1,421 | 1,582 | 1,875 | 161 | 11% | 293 | 19% |
| 1.2 Импорт Ф.О.Б (дебит) | 1,205 | 1,597 | 1,606 | 393 | 33% | 8 | 1% |
| **2. Үйлчилгээ** | **-182** | **-362** | **-192** | **-180** | **-99%** | **169** | **47%** |
| Кредит | 355 | 413 | 525 | 58 | 16% | 112 | 27% |
| Дебет | 537 | 775 | 717 | 238 | 44% | -57 | -7% |
| 2.1 Тээвэр | -52 | -133 | -120 | -81 | -156% | 13 | 10% |
| Кредит | 89 | 97 | 141 | 7 | 8% | 45 | 46% |
| Дебит | 141 | 229 | 261 | 88 | 62% | 32 | 14% |
| 2.2 Аялал | 62 | 5 | 37 | -58 | -93% | 33 | 706% |
| Кредит | 207 | 230 | 273 | 23 | 11% | 43 | 19% |
| Дебит | 145 | 226 | 235 | 81 | 56% | 10 | 4% |
| 2.3 Бусад үйлчилгээ | -192 | -234 | -110 | -41 | -21% | 124 | 53% |
| Кредит | 59 | 86 | 111 | 27 | 46% | 25 | 29% |
| Дебит | 251 | 320 | 221 | 68 | 27% | -99 | -31% |
| **3 Анхдагч орлого** | **-379** | **-295** | **-411** | **85** | **22%** | **-116** | **-40%** |
| Кредит | 20 | 88 | 103 | 69 | 350% | 15 | 17% |
| Дебет | 399 | 383 | 514 | -16 | -4% | 131 | 34% |
| 3.1 Ажилчдын цалин | -10 | 47 | 52 | 57 | 555% | 5 | 11% |
| 3.2 Хөрөнгө оруулалтын орлого | -370 | -344 | -475 | 26 | 7% | -131 | -38% |
| 3.3 Бусад | 1 | 3 | 12 | 2 | | 9 | 310% |
| **4 Хоёрдогч орлого** | **48** | **105** | **78** | **58** | **120%** | **-27** | **-26%** |
| Кредит | 71 | 140 | 120 | 69 | 97% | -20 | -14% |
| Дебит | 23 | 34 | 42 | 11 | 49% | 8 | 23% |
| Үүнээс: Хувийн гуйвуулга | 6 | 55 | 43 | 50 | 902% | -13 | -23% |
| **II. ХӨРӨНГИЙН ДАНС** | **25** | **21** | **26** | **-4** | **-15%** | **5** | **24%** |
| **1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт** | **0** | **0** | **0** | **0** | | **0** | |
| Кредит | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| Дебет | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| **2. Хөрөнгийн шилжүүлэг** | **25** | **21** | **26** | **-4** | **-15%** | **5** | **24%** |
| Кредит | 25 | 21 | 27 | -4 | -15% | 6 | 26% |
| Дебет | 1 | 0 | 1 | 0 | -49% | 1 | 179% |
| **Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)** | **-272** | **-546** | **-230** | **-273** | **-100%** | **315** | **58%** |
| **III. САНХҮҮГИЙН ДАНС** | **-431** | **-415** | **-283** | **16** | **4%** | **132** | **32%** |
| **Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)** | **-431** | **-415** | **-283** | **16** | **4%** | **132** | **32%** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт** | **-439** | **-468** | **-421** | **-28** | **-6%** | **47** | **10%** |
| 1.1 Актив | 24 | 5 | 17 | -19 | -78% | 12 | 238% |
| 1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 24 | 6 | 17 | -18 | -76% | 12 | 205% |
| 1.1.2 Өрийн хэрэгсэл | 0 | -1 | 0 | -1 | | 0 | |
| 1.2 Пассив | 463 | 473 | 438 | 10 | 2% | -35 | -7% |
| 1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 208 | 65 | 232 | -143 | -69% | 167 | 256% |
| 1.2.2 Өрийн хэрэгсэл | 255 | 408 | 206 | 153 | 60% | -202 | -50% |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | **-84** | **-12** | **-42** | **72** | **86%** | **-29** | **-243%** |
| 2.1 Актив | -23 | 9 | -1 | 32 | 138% | -10 | -116% |
| 2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | -25 | 9 | 0 | 34 | 135% | -9 | -97% |
| 2.1.2 Өрийн бичиг | 2 | 0 | -2 | -2 | -100% | -2 | |
| 2.2 Пассив | 61 | 21 | 40 | -40 | -66% | 19 | 92% |
| 2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | -1 | 0 | 2 | 1 | 76% | 2 | 758% |
| 2.2.2 Өрийн бичиг | 62 | 21 | 38 | -41 | -66% | 17 | 80% |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд** | **1** | **28** | **-1** | **27** | **3332%** | **-29** | **-104%** |
| 3.1 Актив | 0 | 3 | -1 | 4 | 1477% | -4 | -133% |
| 3.2 Пассив | -1 | -25 | 0 | -24 | -2249% | 25 | 100% |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | **92** | **37** | **180** | **-55** | **-60%** | **143** | **384%** |
| 4.1 Актив | 268 | -170 | 175 | -438 | -163% | 345 | 203% |
| 4.1.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах | 298 | -152 | 127 | -450 | -151% | 279 | 183% |
| 4.1.3 Зээл | -3 | -3 | -1 | 0 | -14% | 2 | 63% |
| 4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -27 | -15 | 49 | 12 | 45% | 64 | 79x |
| 4.1.5.1 Богино хугацаат | -27 | -15 | 49 | 12 | 45% | 64 | 79x |
| 4.1.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.5 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2 Пассив | 176 | -207 | -5 | -384 | -217% | 202 | 98% |
| 4.2.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах | 83 | -31 | -6 | -114 | -138% | 25 | 81% |
| 4.2.3 Зээл | 23 | -137 | 43 | -160 | -704% | 180 | 131% |
| 4.2.3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд | 9 | -65 | -22 | -74 | -795% | 43 | 66% |
| 4.2.3.3.1 Богино хугацаат | -5 | -20 | 4 | -15 | -313% | 24 | 118% |
| 4.2.3.3.2 Урт хугацаат | 14 | -44 | -26 | -59 | -414% | 19 | 42% |
| 4.2.3.2 Засгийн газар | 126 | 69 | 32 | -57 | -45% | -36 | -53% |
| 4.2.3.4 Бусад салбар | -112 | -141 | 33 | -29 | -26% | 174 | 123% |
| 4.2.3.4.1 Богино хугацаат | -36 | -39 | -29 | -3 | -8% | 10 | 27% |
| 4.2.3.4.2 Урт хугацаат | -76 | -102 | 61 | -26 | -35% | 164 | 160% |
| 4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | 71 | -39 | -42 | -110 | -154% | -3 | -8% |
| 4.2.5.1 Богино хугацаат | 71 | -39 | -42 | -110 | -154% | -3 | -8% |
| 4.2.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.6 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.7 Зээлжих тусгай эрх | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| **IV. Алдаа болон орхигдуулга** | **117** | **-172** | **-245** | **-290** | **-2** | **-72** | **0** |
| **V. НӨӨЦ ХӨРӨНГӨ** | **276** | **-303** | **-192** | **-579** | **-210%** | **112** | **37%** |
| 1. ГВУН | 276 | -303 | -192 | -579 | | 112 | |
| 2. ОУВС-гийн зээл | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 3. Тусгай санхүүжилт | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |

** [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.*

**ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/2018 | 03/31/2019 | 6/30/2019 | 9/30/2019 |
|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | **(33,630)** | **(34,345)** | **(34,442)** | **(34,814)** |
| **Актив** | **6,156** | **6,540** | **6,854** | **6,933** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **533** | **545** | **564** | **582** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **466** | **477** | **496** | **514** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 466 | 477 | 496 | 514 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **67** | **68** | **68** | **68** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 66 | 68 | 67 | 67 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 1 | 1 | 1 | 1 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **297** | **288** | **292** | **289** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 279 | 271 | 267 | 266 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 23 | 22 | 23 | 22 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 256 | 249 | 244 | 244 |
| Бусад санхүүгийн байгууллага | 210 | 213 | 218 | 219 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 46 | 36 | 26 | 25 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 18 | 18 | 25 | 24 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 7 | 7 | 9 | 6 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 10 | 10 | 16 | 17 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 10 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 6 | 7 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **0** | **3** | **5** | **4** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 0 | 3 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 5 | 4 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 5 | 4 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **1,784** | **2,050** | **1,899** | **2,079** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **1,283** | **1,517** | **1,374** | **1,504** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 461 | 806 | 660 | 871 |
| үүнээс: Банк хоорондын позиц | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 822 | 711 | 714 | 633 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 822 | 711 | 714 | 633 |
| **Зээл** | **150** | **156** | **156** | **156** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 150 | 156 | 156 | 156 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | (0) | 0 | 1 | 0 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **352** | **376** | **369** | **419** |
| **Бусад дансны авлага/өглөг** | 0 | 0 | 0 | 0 |
| **Нөөц хөрөнгө** | **3,542** | **3,653** | **4,094** | **3,978** |

| Үзүүлэлт | 12/31/2018 | 03/31/2019 | 6/30/2019 | 9/30/2019 |
|---|---|---|---|---|
| **Гадаад пассив** | **39,786** | **40,884** | **41,296** | **41,747** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **20,223** | **20,697** | **21,184** | **21,568** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **10,995** | **11,288** | **11,525** | **11,734** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 10,995 | 11,288 | 11,525 | 11,734 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **9,228** | **9,409** | **9,659** | **9,834** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 9,228 | 9,409 | 9,659 | 9,834 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **4,887** | **5,231** | **5,260** | **5,414** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 75 | 74 | 78 | 79 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 21 | 21 | 21 | 21 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 54 | 53 | 57 | 58 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 4,811 | 5,157 | 5,182 | 5,334 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 624 | 640 | 632 | 628 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 2,946 | 2,970 | 2,941 | 3,095 |
| Бусад салбарууд | 1,241 | 1,547 | 1,610 | 1,612 |
| Бусад санхүүгийн байгууллага | 787 | 1,102 | 1,099 | 1,121 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 451 | 443 | 60 | 53 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **1** | **0** | **0** | **0** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 1 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **14,675** | **14,956** | **14,852** | **14,765** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **2,123** | **2,199** | **2,086** | **2,015** |
| Төв банк | 1,745 | 1,786 | 1,747 | 1,683 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 327 | 402 | 339 | 332 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 51 | 11 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллага | 51 | 11 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 |
| **Зээл** | **12,265** | **12,389** | **12,369** | **12,375** |
| Төв банк | 286 | 287 | 286 | 265 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 1,279 | 1,352 | 1,274 | 1,250 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 4,238 | 4,293 | 4,306 | 4,279 |
| Бусад салбарууд | 6,462 | 6,458 | 6,503 | 6,582 |
| Бусад санхүүгийн байгууллага | 292 | 300 | 331 | 424 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 6,170 | 6,158 | 6,172 | 6,158 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **288** | **368** | **396** | **375** |
| **Бусад дансны авлага/өглөг** | **0** | **0** | **0** | **0** |

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/2017 | 3/31/2018 | 6/30/2018 | 9/30/2018 | 12/31/2018 | 3/31/2019 | 6/30/2019 | 9/30/2019 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Засгийн газар** | **7,321** | **7,242** | **6,929** | **7,049** | **7,184** | **7,262** | **7,246** | **7,374** |
| **Богино хугацаат** | - | - | - | - | - | - | - | - |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 7,321 | 7,242 | 6,929 | 7,049 | 7,184 | 7,262 | 7,246 | 7,374 |
| Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/ | - | - | - | - | - | - | - | - |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 3,549 | 3,340 | 2,996 | 3,067 | 2,946 | 2,970 | 2,941 | 3,095 |
| Зээл | 3,772 | 3,902 | 3,933 | 3,981 | 4,238 | 4,293 | 4,306 | 4,279 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Төвбанк** | **2,025** | **2,137** | **2,065** | **1,996** | **2,030** | **2,072** | **2,034** | **1,948** |
| **Богино хугацаат** | 1,837 | 1,913 | 1,811 | 1,744 | 1,745 | 1,786 | 1,747 | 1,683 |
| Харилцах, хадгаламж 5/ | 1,837 | 1,913 | 1,811 | 1,744 | 1,745 | 1,786 | 1,747 | 1,683 |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 188 | 224 | 253 | 252 | 286 | 287 | 286 | 265 |
| Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/ | 188 | 224 | 253 | 252 | 286 | 287 | 286 | 265 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)** | **2,194** | **2,347** | **2,311** | **2,309** | **2,230** | **2,393** | **2,245** | **2,209** |
| **Богино хугацаат** | 659 | 769 | 777 | 777 | 764 | 780 | 722 | 680 |
| Харилцах, хадгаламж 5/ | 314 | 330 | 297 | 317 | 327 | 402 | 339 | 332 |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | 345 | 439 | 480 | 460 | 437 | 378 | 383 | 348 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 1,535 | 1,578 | 1,534 | 1,532 | 1,466 | 1,613 | 1,523 | 1,529 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 589 | 608 | 596 | 633 | 624 | 640 | 632 | 628 |
| Зээл | 946 | 970 | 938 | 900 | 842 | 973 | 891 | 902 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Бусад салбарууд** | **7,956** | **7,944** | **7,895** | **7,676** | **8,042** | **8,385** | **8,509** | **8,569** |
| **Богино хугацаат** | 666 | 665 | 647 | 536 | 609 | 630 | 662 | 622 |
| Харилцах, хадгаламж 5/ | 95 | 122 | 102 | 40 | 51 | 11 | - | - |
| Өрийн бичиг 4/ | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| Зээл | 292 | 274 | 277 | 259 | 275 | 269 | 284 | 265 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 277 | 266 | 266 | 235 | 281 | 347 | 376 | 355 |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 7,289 | 7,279 | 7,248 | 7,141 | 7,433 | 7,755 | 7,847 | 7,947 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 726 | 736 | 731 | 724 | 1,239 | 1,545 | 1,607 | 1,610 |
| Зээл | 6,560 | 6,536 | 6,510 | 6,409 | 6,187 | 6,189 | 6,219 | 6,317 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 3 | 7 | 7 | 7 | 7 | 20 | 20 | 20 |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг** | **7,996** | **8,235** | **8,461** | **8,871** | **9,228** | **9,409** | **9,659** | **9,834** |
| Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг | 7,996 | 8,235 | 8,461 | 8,871 | 9,228 | 9,409 | 9,659 | 9,834 |
| Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг | - | - | - | - | - | - | - | - |
| Хамааралтай компани хоорондын өглөг | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт гадаад өр** | **27,493** | **27,905** | **27,661** | **27,902** | **28,715** | **29,522** | **29,693** | **29,934** |